

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд:

“ХИҮ.4. “Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд барих төмөр замын төсөлд “Энержи Ресурс” ХХК болон “Энержи Ресурс Рэйл” ХХК-ийн оруулсан хөрөнгө оруулалт, зардлын тооцоог хянах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газар, “Энержи Ресурс” ХХК болон “Энержи Ресурс Рэйл” ХХК-ийн хооронд 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан “Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-г цуцлах талаар гэрээ байгуулах нь зүйтэй гэж үзэв.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР